

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/06/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Говьсүмбэр аймаг 2024 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Дарханбат Цахим хаяг: <a href="mailto:darkhanbatb@audit.gov.mn">darkhanbatb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2024.05.15 № 48

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020127

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь Сүмбэр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулсан бөгөөд 3 зорилт 12 арга хэмжээ төлөвлөж 85 хувьтай хэрэгжсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>124,778,361.25</b>	<b>87,296,695.66</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>33,269,457.03</b>	<b>18,246,838.66</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>33,269,457.03</b>	<b>18,246,838.66</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>33,269,457.03</b>	<b>18,246,838.66</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	33,269,457.03	18,246,838.66
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>35,680,104.22</b>	<b>34,194,657.00</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	53,818.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>35,680,104.22</b>	<b>34,140,839.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	35,680,104.22	34,081,839.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	59,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>55,828,800.00</b>	<b>34,855,200.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>55,828,800.00</b>	<b>34,855,200.00</b>
35420	Аж ахуйн материал	55,828,800.00	34,855,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,434,923,766.97</b>	<b>11,947,648,251.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,434,923,766.97</b>	<b>11,947,648,251.13</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>8,206,294,135.96</b>	<b>11,729,061,970.76</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,743,221.80	2,690,024,020.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,581,355.59	-40,356,982.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	792,190,000.00	854,462,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-265,103,333.04	-338,320,266.30
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,756,000.00	15,256,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,452,991.67	-7,626,158.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,482,328.57	6,482,328.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,535,929.01	-4,620,565.93
39209	Зам, гүүрийн байгууламж	6,989,377,749.00	7,540,060,615.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,767,998,628.26	-2,181,241,384.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,142,466,384.00	6,480,449,948.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,707,049,309.84	-3,285,507,584.68
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>228,629,631.01</b>	<b>218,586,280.37</b>
39301	Програм хангамж	20,118,374.00	20,118,374.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,888,194.64	-14,239,593.68
39303	Бусад биет бус хөрөнгө	317,890,000.00	317,890,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-99,490,548.35	-105,182,499.95
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,559,702,128.22</b>	<b>12,034,944,946.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,949,783,210.66</b>	<b>10,278,403,255.06</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,198,749.85</b>	<b>61,900.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>4,198,749.85</b>	<b>61,900.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>4,198,749.85</b>	<b>61,900.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	4,198,749.85	61,900.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,945,584,460.81</b>	<b>10,278,341,355.06</b>
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>5,945,584,460.81</b>	<b>10,278,341,355.06</b>
<b>42210</b>	<b>Төгрөг</b>	<b>5,945,584,460.81</b>	<b>10,278,341,355.06</b>
42241	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	5,945,584,460.81	10,278,341,355.06
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,609,918,917.56</b>	<b>1,756,541,691.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,609,918,917.56</b>	<b>1,756,541,691.73</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,202,002,208.14	2,202,002,208.14
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,202,002,208.14	2,202,002,208.14
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>401,111,378.54</b>	<b>-452,265,847.29</b>

51210	Өмнөх үеийн үр дүн	1,381,628,456.84	401,111,378.54
51220	Тайлант үеийн үр дүн	-980,517,078.30	-853,377,225.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,805,330.88	6,805,330.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,559,702,128.22</b>	<b>12,034,944,946.79</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>750,415,424.00</b>	<b>1,070,334,737.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>750,415,424.00</b>	<b>1,070,334,737.21</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>750,415,424.00</b>	<b>1,070,334,737.21</b>
120009	Бусад орлого	651,384,272.00	910,881,700.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	99,031,152.00	159,453,037.21
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,730,932,502.30</b>	<b>1,911,711,963.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,730,932,502.30</b>	<b>1,911,711,963.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,730,932,502.30</b>	<b>1,911,711,963.04</b>
<b>210811</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/</b>	<b>1,730,932,502.30</b>	<b>1,911,711,963.04</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-980,517,078.30</b>	<b>-841,377,225.83</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>12,000,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	12,000,000.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-980,517,078.30</b>	<b>-853,377,225.83</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56
2	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56
4	Тайлант үеийн үр дүн	0	0	-853,377,225.83	-853,377,225.83
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-452,265,847.29	1,756,541,691.73

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>676,951,707.00</b>	<b>1,000,467,473.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>676,951,707.00</b>	<b>1,000,467,473.21</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>676,951,707.00</b>	<b>1,000,467,473.21</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>41,608,343.00</b>	<b>93,423,773.21</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,848,626.00	89,487,305.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,759,717.00	3,936,468.21
120009	Бусад орлого	635,343,364.00	907,043,700.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>681,625,136.92</b>	<b>1,009,990,091.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>681,625,136.92</b>	<b>1,009,990,091.58</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>681,625,136.92</b>	<b>1,009,990,091.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>206,743,176.00</b>	<b>337,216,483.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	206,743,176.00	337,216,483.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,100,837.86</b>	<b>97,631,030.91</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	63,100,837.86	97,631,030.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,514,270.00</b>	<b>70,253,163.48</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	92,514,270.00	70,253,163.48
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>258,114,109.20</b>	<b>186,457,983.00</b>
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	258,114,109.20	186,457,983.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>61,152,743.86</b>	<b>318,431,431.19</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12,270,318.36	28,185,486.85
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	48,882,425.50	290,245,944.34
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-4,673,429.92</b>	<b>-9,522,618.37</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>5,500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>5,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>5,500,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	5,500,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>-5,500,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-4,673,429.92</b>	<b>-15,022,618.37</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,942,886.95	33,269,457.03
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,269,457.03	18,246,838.66

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Байхгүй

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

### 1. Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Хар сувд хамтлагт 1.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 16 дугаар зүйлийн 16.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### 2. Илрүүлэлт:

Албан ажлын машин болон тусгай зориулалтын автомашинуудад тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

### 1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 101.9 сая төгрөгийн 4, зарлагын 46.5 сая төгрөгийн 5 гүйлгээ, хандив тусламжийн зарцуулалтыг тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6 дугаар зүйлийн 6.3.5, 6.4.5-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

Аудитаар нийт 6.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад алдааг бүрэн залруулсан.

- *Үндсэн хөрөнгө худалдаж авахад төлсөн 5.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, ангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын "Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ", УСНББОУС-2-25А гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдээдлийг хангаагүй*
- *Томилолтоор ажилласан албан хаагчдад 0.05 сая төгрөгийн хоолны унааны олговрыг давхардуулж олгосон. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2, 2.2.3 гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангаагүй.*
- *Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэн ирүүлээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 16 дугаар зүйлийн 16.2, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1 дүгээр зүйл "Санхүүгийн тайлангийн*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*бүрэлдэхүүн гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.*

- *3 ажилтны 31 хоногийн 1.0 сая төгрөгийн цалин хөлсийг ээлжийн амралттай давхардуулж олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.*

Аудитаар нийт 1.9 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн.

## **5.1 Төлбөрийн акт**

### 1. Илрүүлэлт

Бараа материалын тайланг нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй, шаардах хуудсанд байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар зөвшөөрөл олгосон гарын үсгийг бүрэн зураагүй буюу анхан шатны хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн. Анхан шатны баримтгүй 703 ш буюу 1.9 сая төгрөгийн бээлийг зарлагаар бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт БМ-6 заалт, Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 1.9 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага өгөөгүй.**

### **5.3 Зөвлөмж**

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой.

##### Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 34 нэр төрлийн 53 ширхэг, 865.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дах заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй хөрөнгөнөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж данс бүртгэлд тусгах

#### 2. Газрын бүртгэлтэй холбоотой.

##### Илрүүлэлт:

Аюултай хог хаягдал түр хадгалах зориулалттай олгосон 25000м<sup>2</sup> газрыг санхүүгийн тайланд үнэлж бүртгээгүй.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх

### 3. Орлогын бүртгэлтэй холбоотой.

#### Илрүүлэлт:

Санхүүгийн программ хангамжийг шинэчлэлтээс шалтгаалж албан байгууллага, айл өрхөөс авах хураамжийн авлагыг харилцагч бүрээр нь бус бөөн дүнгээр нь бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасныг тус тус зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Авлагыг айл өрх, албан байгууллага бүрээр нь тооцоо үүсгэж, санхүүгийн программ хангамжаар бүртгэх

#### **Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

##### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тохжилт Сүмбэр ОНӨААТҮГ	4	6.6	1	0	3	6.6	4	6.6				
Дүн	4	6.6	1	0	3	6.6	4	6.6				

##### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тохжилт Сүмбэр ОНӨААТҮГ	3	1.9	1	1.9			2	0				
Дүн	3	1.9	1	1.9			2	0				

##### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тохжилт Сүмбэр ОНӨААТҮГ	1	148.4			1	148.4		

Дүн	1	148.4			1	148.4		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төхижилт Сүмбэр ОНӨААТҮГ	2	1	1	1.0				
Дүн	2	1	1	1.0				
Нийт дүн	3	149.4	1	1	1	148.4	1	0

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			